

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/132/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.4 Материаллаг байдал.....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Төлбөрийн акт	20
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж.....	21
5 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭЭС	Эргэлтийн эмийн сан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/170
танай _____ -ны № _____ -г

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА С.БАЯНМӨНХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны эцэст 386,831.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 86,123.3 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг гүйцэтгээгүй, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 85,683.1 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж данс бүртгэлд тусгаагүй, бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 3,364.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэж тайлагнасан зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 72.4.1 "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, УСНББОУС 12 Бараа материал, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгөд нийцэхгүй, "Оршин байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Д 2022/2022-132/НА-СТА-ТШЗ 13087529

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,760,007.92	168,075,431.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	31,416,620.21
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	31,416,620.21
3121	Төгрөг	00.00	31,416,620.21
31211	Төрийн сангийн харилцах	00.00	28,918,684.21
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	2,497,936.00
33	АВЛАГА	00.00	50,535,536.00
335	Бусад авлага	00.00	50,535,536.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	50,535,536.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,760,007.92	86,123,274.92
351	Түүхий эд материал	21,382,640.52	46,337,867.52
35130	Эм боох материал	21,382,640.52	46,337,867.52
354	Хангамжийн материал	27,377,367.40	39,785,407.40
35410	Бичиг хэргийн материал	1,220,800.00	1,240,750.00
35420	Аж ахуйн материал	22,084,576.00	33,383,976.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	1,610,800.00
35450	Барилгын засварын материал	34,000.00	34,000.00
35460	Хүнсний материал	1,658,690.40	1,136,580.40
35470	Бусад хангамжийн материал	2,379,301.00	2,379,301.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	390,362,664.57	386,831,087.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	390,362,664.57	386,831,087.17
392	Биет хөрөнгө	370,362,664.57	366,831,087.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	341,037,422.00	341,037,422.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-32,645,830.20	-42,488,191.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,018,350.00	58,018,350.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,190,850.11	-42,480,850.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	98,040,935.50	114,186,585.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-65,058,310.81	-69,614,670.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,528,710.00	42,457,210.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,572,761.45	-35,894,928.01
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,300,000.00	2,776,410.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,095,000.36	-1,166,250.39
393	Биет бус хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39301	Программ хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	439,122,672.49	554,906,518.30
4	НИИТ ӨР ТӨЛБӨР	00.00	820,200.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	820,200.00
413	Өглөг	00.00	820,200.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	820,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	439,122,672.49	554,086,318.30
51	Засгийн газрын хувь оролцоо	439,122,672.49	554,086,318.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	173,651,422.00	173,651,422.00
51101	Өмч: - төрийн	173,651,422.00	173,651,422.00
512	Хуримтлагдсан үр дүн	-11,973,160.04	102,990,485.77
51210	Өмнөх үеийн үр дүн	-11,973,160.04	-11,973,160.04
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	114,963,645.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	277,444,410.53	277,444,410.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	439,122,672.49	554,906,518.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	340,224,563.01	478,467,681.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	28,314,300.00
110	Орлогын албан татвар	00.00	28,314,300.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	00.00	28,314,300.00
110002	Үйл ажиллагааны орлого	00.00	28,314,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,307,798.01	370,551,105.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,307,798.01	47,521,105.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,307,798.01	7,873,060.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,307,798.01	7,873,060.00
120009	Бусад орлого	00.00	39,648,045.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	323,030,000.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	323,030,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,319,865.00	79,602,276.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	281,596,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,926,535.00	20,265,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,926,535.00	20,265,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,314,300.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,314,300.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,079,030.00	59,337,276.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,079,030.00	59,337,276.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	350,328,162.36	363,504,035.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	350,328,162.36	361,081,035.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	338,616,297.00	357,121,230.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,141,717.45	240,364,611.87
210101	Үндсэн цалин	149,102,770.44	125,823,052.57
210102	Нэмэгдэл	61,671,969.61	73,627,772.79
210104	Урамшуулал	14,366,977.40	40,913,786.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,137,244.39	30,441,502.92
210201	Тэтгэврийн даатгал	20,642,235.57	21,562,069.16
210202	Тэтгэмжийн даатгал	2,064,823.95	2,203,859.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,652,019.12	1,763,087.37
210204	Ажилгүйдлийн даатгал	412,804.82	428,407.97
210205	Эрүүл мэндийн даатгал	4,365,360.94	4,484,079.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,131,900.00	24,222,295.00
210301	Гэрэл, цахилгаан	1,643,269.00	3,434,432.00
210302	Түлш, халаалт	19,488,631.00	20,787,863.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,972,811.29	24,642,770.00
210401	Бичиг хэрэг	1,632,550.50	1,466,600.00
210402	Тээвэр, шатахуун	11,061,200.00	20,721,670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	834,000.00	864,000.00

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	404,500.00	185,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,743,830.79	00.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	4,296,730.00	1,405,500.00
2105	Нормативт зардал	10,288,516.10	12,852,493.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,538,183.50	4,788,608.00
210502	Хоол, хүнс	5,750,332.60	8,063,885.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,477,700.00	1,925,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	632,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	845,700.00	376,000.00
210604	Урсгал засвар	00.00	1,549,000.00
2107	Томилолт, зочны зардал	140,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	140,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	477,450.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	153,450.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,848,957.77	22,672,557.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	751,288.00	1,590,420.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,097,669.77	21,082,137.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,711,865.36	3,959,805.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,189,400.00	2,959,805.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,189,400.00	2,959,805.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,522,465.36	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,522,465.36	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	2,423,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	2,423,000.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	2,423,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-10,103,599.35	114,963,645.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-10,103,599.35	114,963,645.81

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,651,422.00	277,444,410.53	-1,892,352.33	449,203,480.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	173,651,422.00	277,444,410.53	-1,892,352.33	449,203,480.20
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-10,103,599.35	-10,103,599.35
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,651,422.00	277,444,410.53	-11,973,160.04	439,122,672.49
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,651,422.00	277,444,410.53	-11,973,160.04	439,122,672.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	173,651,422.00	277,444,410.53	-11,973,160.04	439,122,672.49
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	114,943,645.81	114,943,645.81
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,651,422.00	277,444,410.53	102,970,485.77	554,066,318.30

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	327,916,765.00	420,494,085.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	28,314,300.00
110	Орлогын албан татвар	00.00	28,314,300.00
110002	Үйл ажиллагааны орлого	00.00	28,314,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	362,678,045.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	39,648,045.00
120009	Бусад орлого	00.00	39,648,045.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	323,030,000.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	323,030,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	327,916,765.00	29,501,740.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	281,596,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,926,535.00	20,265,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,926,535.00	20,265,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,314,300.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,314,300.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,079,030.00	9,236,740.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,079,030.00	9,236,740.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	327,916,765.00	389,077,464.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	327,916,765.00	389,077,464.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	316,204,899.64	385,117,659.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,141,717.45	240,364,611.87
210101	Үндсэн цалин	149,102,770.44	125,823,052.57
210102	Нэмэгдэл	61,671,969.61	73,627,772.79
210104	Урамшуулал	14,366,977.40	40,913,786.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,137,244.39	30,441,502.92
210201	Тэтгэврийн даатгал	20,642,235.56	21,562,069.16
210202	Тэтгэмжийн даатгал	2,064,823.95	2,203,859.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,652,019.12	1,763,087.37
210204	Ажилгүйдлийн даатгал	412,804.82	428,407.97
210205	Эрүүл мэндийн даатгал	4,365,360.94	4,484,079.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,131,900.00	24,222,295.00
210301	Гэрэл, цахилгаан	1,643,269.00	3,434,432.00
210302	Түлш, халаалт	19,488,631.00	20,787,863.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,501,680.00	24,599,820.00
210401	Бичиг хэрэг	925,250.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,968,700.00	20,667,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	834,000.00	900,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,773,730.00	2,032,100.00

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	13,168,119.80	30,553,380.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,720,989.80	23,905,835.00
210502	Хоол, хүнс	6,447,130.00	6,647,545.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,742,700.00	21,732,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,709,000.00	9,056,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,040,700.00	6,760,000.00
210604	Урсгал засвар	993,000.00	5,916,200.00
2107	Томилолт, зочны зардал	140,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	140,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,477,450.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	153,450.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,764,088.00	13,203,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,764,088.00	13,203,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,711,865.36	3,959,805.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,189,400.00	2,959,805.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,189,400.00	2,959,805.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,522,465.36	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,522,465.36	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	31,416,620.21
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	31,416,620.21
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	31,416,620.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	370,230,500.0	328,748,108.8	41,482,391.2	88.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	370,230,500.0	328,748,108.8	41,482,391.2	88.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	370,230,500.0	328,748,108.8	41,482,391.2	88.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,142,700.0	222,323,637.9	34,819,062.1	86.5
210101	Үндсэн цалин	160,735,500.0	125,823,052.6	34,912,447.4	78.3
210102	Нэмэгдэл	67,508,900.0	73,140,227.0	(5,631,327.0)	108.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,788,000.0		4,788,000.0	-
210104	Урамшуулал	24,110,300.0	23,360,358.3	749,941.7	96.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,714,300.0	30,441,502.9	4,272,797.1	87.7
210201	Тэтгэврийн даатгал	24,428,600.0	21,610,729.1	2,817,870.9	88.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,571,400.0	2,155,199.3	416,200.7	83.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,057,200.0	1,763,087.4	294,112.6	85.7
210204	Ажилгүйдлийн даатгал	514,300.0	428,408.0	85,892.0	83.3
210205	Эрүүл мэндийн даатгал	5,142,800.0	4,484,079.1	658,720.9	87.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,164,300.0	26,783,563.0	380,737.0	98.6
210301	Гэрэл, цахилгаан	5,995,700.0	5,995,700.0	-	100.0
210302	Түлш, халаалт	20,787,600.0	20,787,863.0	(263.0)	100.0
210303	Цэвэр, бохир ус	381,000.0		381,000.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	19,870,000.0	19,809,710.0	60,290.0	99.7
210401	Бичиг хэрэг	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	16,170,000.0	16,132,310.0	37,690.0	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.0	900,000.0	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.0	1,777,400.0	22,600.0	98.7
2105	Нормативт зардал	18,889,200.0	18,145,495.0	743,705.0	96.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,889,200.0	11,435,650.0	453,550.0	96.2
210502	Хоол, хүнс	7,000,000.0	6,709,845.0	290,155.0	95.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,750,000.0	5,835,700.0	(85,700.0)	101.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.0	1,547,500.0	52,500.0	96.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.0	3,000,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	1,150,000.0	1,288,200.0	(138,200.0)	112.0
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.0	-	1,000,000.0	-
210702	Дотоод албан томилолт	1,000,000.0		1,000,000.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,700,000.0	5,408,500.0	291,500.0	94.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,700,000.0	5,408,500.0	291,500.0	94.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	370,230,500.0	357,909,330.0	12,321,170.0	96.7

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	323,030,000.0	323,030,000.0	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	323,030,000.0	323,030,000.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,314,300.0	28,314,300.0	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	28,314,300.0	28,314,300.0	-	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,886,200.0	6,565,030.0	12,321,170.0	34.8
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,886,200.0	6,565,030.0	12,321,170.0	34.8
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	16.0	16.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	7.0	7.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	8.0	8.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,086,819.00	59,086,819.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,086,819.00	59,086,819.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,086,819.00	59,086,819.00	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,040,974.00	18,040,974.00	
210102	Нэмэгдэл	487,545.83	487,545.83	
210104	Урамшуулал	17,553,428.17	17,553,428.17	
2104	Хангамж, бараа материалын зардал	4,790,110.00	4,790,110.00	
210402	Тээвэр, шатахуун	4,535,410.00	4,535,410.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	254,700.00	254,700.00	
2105	Нормативт зардал	12,470,185.00	12,470,185.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,470,185.00	12,470,185.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,897,000.00	15,897,000.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,509,000.00	7,509,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,760,000.00	3,760,000.00	
210604	Урсгал засвар	4,628,000.00	4,628,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,888,550.00	7,888,550.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,888,550.00	7,888,550.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,584,755.00	61,584,755.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,584,755.00	61,584,755.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,584,755.00	61,584,755.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	2,497,936.00	2,497,936.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,497,936.00	2,497,936.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет болон биет бус хөрөнгийг шийдвэрлэх, хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэж, хөрөнгийн шамшигдал үүсгэхгүй ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төв нь бүхний эрүүл мэндийн төлөө хамтдаа зүтгэн, сумын эрүүл мэндийн төвийн стандартын хангалтыг сайжруулан, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, сумын иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийг эрхэм зорилгоо болгон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө гарган батлуулж, дотоод үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын ажлын тайланг улирал бүр тайлагнасан байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төв нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 370,230.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,553.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,165.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 370,230.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 357,909.3 мянган төгрөгийн санхүүжилтийг 96.7 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 61,584.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 378,399.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 16,145.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 928.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 476.4 мянган төгрөгийн бусад хөрөнгө, нийт 17,550.6 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 9,677.5 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 5,896.7 мянган төгрөгийн, бусад 1,976.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 76,862.8 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 39,499.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 50,535.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, 820.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Энэ нь ЭМДЕГ-аас 10,11,12 дугаар сарын санхүүжилт хийгдээгүй санхүүжилтийн авлага байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулаагүй байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн дансанд 28,918.7 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансанд 2,497.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлгүй байна. Бараа материал 86,123.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 386,831.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		31,416.6	31,416.6
Авлага		50,535.5	50,535.5
Урьдчилгаа			-
Бараа материал	48,760.0	86,123.3	37,363.3
Үндсэн хөрөнгө	390,339.9	386,831.1	(3,508.8)
Нийт хөрөнгө	439,099.9	554,906.5	115,806.6
Өр төлбөр	-	820.2	820.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	439,099.9	554,086.3	114,986.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	439,099.9	554,906.5	115,806.6

Бараа материалын дансны үлдэгдэл 86,123.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 37,363.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 386,831.1 мянган төгрөг болж 3,508.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлээс шалтгаалж байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 554,086.3 мянган төгрөг болж 114,986.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 370,230.5 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 370,230.5 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 370,230.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 323,030.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 28,314.3 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 6,565.0 мянган төгрөгийн, нийт 357,909.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 328,748.1 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, 2,959.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, зарцуулаагүй үлдэгдэл 28,918.7 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 328,748.1 мянган төгрөг буюу 88.8 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 61,584.8 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний бусад зардалд 59,086.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй 2,497.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 16,145.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 928.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 476.4 мянган төгрөгийн бусад хөрөнгө, нийт 17,550.6 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 9,677.5 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 5,896.7 мянган төгрөгийн, бусад 1,976.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст 386,831.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 86,123.3 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг гүйцэтгээгүй, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 85,683.1 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж данс бүртгэлд тусгаагүй, бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 3,364.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэж тайлагнасан зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, 72 дугаар зүйлийн 72.4.1-д “Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг хэрэгжүүлээгүй, УСНББОУС 12 Бараа материал, УСНББОУС 17

Үндсэн хөрөнгөд нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Оршин байх”, “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 71 мэдээллийг хугацаандаа, 43 мэдээллийг хугацаа хоцроож, 32 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар бүрэн ирүүлээгүй. Баянцагаан сумын Эргэлтийн эмийн сангийн анхан шатны нотлох дэмжих баримт, холбогдох тайлан мэдээ, тайлант оны санхүүгийн тайланг аудитын байгууллагад ирүүлээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 148,505.8 мянган төгрөгийн зөрчил арилгах 2 албан шаардлага, 316.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 2 алдаа зөрчил тайлант онд давтан гарч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвд санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 141,136.5 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 22.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 260.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 137,038.8 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлага хүргүүлж, 3,814.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 22.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудитлагдсан тайлантай тулгахад нийт хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 22.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 260.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Бараа материалын дансанд тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 260.5 мянган төгрөгийн хүнсний материал бүртгэлтэй, бодитоор оршин байгаа нь тооллогын баримтаар нотлогдохгүй байгаа нь: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.22-д "Төсөвт байгууллага нь бараа материалын өртгийг тодорхойлохдоо эхэлж авсныг эхэлж зарлагадах аргыг ашиглана. Эхэлж авсныг эхэлж зарлагадах аргын үед эхэлж худалдан авсан бараа материалыг эхэлж зарцуулна", УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн тооллогын баримтаар нотлогдохгүй бараа материалыг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар 137,038.8 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 85 нэр төрлийн 85,683.1 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байгаа нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх

аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэх хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 71 мэдээллийг хугацаандаа, 43 мэдээллийг хугацаа хоцроож, 32 мэдээллийг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

3. Тус байгууллага нь 2021 оны жилийн эцэст эргэлтийн хөрөнгийн тооллого хийгээгүй, тооллоготой холбоотой баримт материалыг аудитын байгууллагад ирүүлээгүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Оршин байх”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн эргэлтийн хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

4. Санхүүгийн тайланд тусгасан авлага, өглөгийн харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн акттай тулгахад 50,535.5 мянган төгрөгийн авлага, 820.2 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь: НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3-д “бүх өр төлбөр”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн тайлант хугацаанд үүссэн авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Бараа материалын данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд бэлтгэсэн 12 нэр төрлийн 3,364.4 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоолын 1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийн анги доторхи зүйлийг НББОУС-д нийцүүлэн зөв ангилан бүртгэх, буруу бүртгэснийг данс хооронд шилжүүлэх замаар залруулан бүртгэхийг дарга, захирал нарт даалгасугай” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэж байх

2. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 3 нэр төрлийн 450.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет бус хөрөнгийг шийдвэрлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төв	8	141,136.5	1	22.8	1	260.5	4	137,038.8	2	3,814.4

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn